

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 249 (5)

НШУС

2005

ЭМЭГТЭЙ СЭТГҮҮЛЧДИЙН ЭРХЭД ХАЛДАЖ БАЙГАА НЬ (Социологийн судалгааны дүн)

Түлхүүр үг: анкетын арга, респондент, эрхэд халдах, заналхийлэл, сурдуулэг.

2005 оны 11-р сард МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмээс эмэгтэй сэтгүүлчдийн эрхэд халдаж байгаа асуудлыг дэлгэх зорилгоор социологийн судалгаа явуулсан юм. Энэхүү судалгааг МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн 4-р курсын оюутнууд тус тэнхмийн багш, доктор Ч.Чойсамбын удирдлаган доор гүйцэтгэсэн болно.

Юуны өмнө «эрх чөлөөнд халдах» гэдгийг бид ямар утгаар авч үзсэнээ тайлбарлах нь зүйтэй болов уу. Нэгдүгээрт, утсаар болон биеэр (уулзаж) заналхийлэх, хоёрдугаарт, бие махбодид нь халдах, энгийнээр хэлбэл зодох, гуравдугаарт, сэтгүүлчтэй өөр хэлбэрээр тооцоо хийх (шүүхэд өгех, эд материалын хохирол учруулах г. м.) гэсэн ойлголтыг хамарсан болно.

Судалгаанд ХМХ-үүдэд ажиллаж буй 100 эмэгтэй сэтгүүлч хамрагдсан бөгөөд тэдний 52% нь тогтмол хэвлэл, 31% нь телевиз, 13% нь радио, 4% нь мэдээллийн агентлаг, хэвлэлийн албанад ажилладаг байна.

Респондентуудын ихэнх нь мэргэжлээрээ ажиллаад төдийлөн удаагүй нь тэдний хариултаас харагдсан юм. Тухайлбал: 60% нь 5 хүртэл сан юм. Тухайлбал: 60% нь 5 хүртэл жил, 33% нь 6-10 жил, өөрөөр хэлбэл

93% нь 11 хүртэл жилийн ажлын туршлагатай ажээ. 1990 оноос хойш манай сэтгүүлчдийн эгнээ маш их залуужсан нь судалгаанд хамрагдагсдын ажилласан жилээс харагдаж байна.

Эрхэлсэн ажилтай нь, бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй нь холбогдуулаад эмэгтэй сэтгүүлчдийн эрхэд халдах үзэгдэл манай нийгэмд маш их газар авсан, бараг хэвийн үзэгдэл болсныг дараах баримт хөдөлбөргүй нотолно. Тухайлбал: судалгаанд хамрагдагсдын 66% нь ямар нэг хэлбэрийн халдлагад өртсөн байна. «Хариулж мэдэхгүй байна» гэж респондентуудын 3% хариулжээ. Гэвч тэдний бөглөсөн анкетыг аваад үзэхэд 3-аас 2 тохиолдолд нь сэтгүүлчийн эрхэд халдсаны шинж илэрсэн юм. Эндээс манай сэтгүүлчид эрх нь зөрчигдэж байгааг тэр бүр ойлгодоггүй, энэ ярвигтай мэргэжлээр ажиллаж байгаа хүний өдөр тутмын үйл ажиллагаанд байх ёстой хэвийн үзэгдэл мэт хүлээж авах, хандах байдал ажиглагдаж байна. Заналхийлэл, халдлагад ихэнхдээ тогтмол хэвлэл, телевизэд ажилладаг сэтгүүлч өртдөг ажээ.

Эрх чөлөөнд халдсан байдлыг ангилж үзэхэд дараах дүр зураг бууж байна (давхардсан тоогоор). Утсаар заналхийлсэн 46 тохиолдол, уулзаж заналхийлсэн 26 тохиолдол, бие махбодид халдсан 8 тохиолдол, эд

материалын хохирол учруулсан 5 тохиолдол гарсан бол «бусад» (шүүхэд өгсөн, ажлаас хапсан, сонин хаасан) гэж 11 сэтгүүлч хариулжээ. Эндээс сэтгүүлчийн элдвэр дарамтлах, заналхийлэх практик өргөн дэлгэрчээ гэж дүгнэж болох юм.

Заналхийлэл, сүрдүүлэг хэнээс гараад байна вэ гэдэг мөн сонирхол татсан асуудал. Заналхийлэгч нь (давхардсан тоогоор) 46 тохиолдолд нийтлэл, нэвтрүүлэгт дурдагдсан хүн, түүний хамсаатан, гарын доор байдаг хүн, тус бүр 22 тохиолдолд нэрээ хэлэхээс татгалзсан хүн, мөн таньдаг хүн, 8 тохиолдолд бусад хүн байна. Хамгийн эмзэглэмээр зүйл юу вэ гэвэл 11 тохиолдолд эмэгтэй сэтгүүлчийг нийтлэл, нэвтрүүлэгтэй нь холбогдуулж дарамталдаг хүн бол дарга нь (эзэн, эрхлэгч г. м.)

байдаг ажээ. Заналхийлэгч этгээд эмэгтэй сэтгүүлчийг дарамтлаад зогсдоггүй байна. Хэрэв заналхийллийн 33 тохиолдолд зөвхөн сэтгүүлчийг сүрдүүлдэг бол 32 тохиолдолд түүний ажилладаг ХМХ-ийг давхар заналхийлдэг, 8 тохиолдолд гэр бүл, ойр дотны хүнийг нь хамруулдаг ажээ.

Заналхийлэгч этгээд эмэгтэй сэтгүүлчийг чухам юу гэж сүрдүүлдэг нь анхаарал татсан юм (давхардсан тоогоор). Ажилгүй болгоно гэж 32 удаа, 24 удаа «нөхөрсгөөр зөвлөсөн», бие маходид нь халдана гэж 15 удаа

заналхийлжээ. Мөн бусад хэлбэрээр ч (компьютер эндэх, шүүхэд хандах, ажлын байр сүйтгэх г. м.) сүрдүүлэх явдал түгээмэл байна (12 тохиолдол). Тэр ч байтугай сэтгүүлчийг «ална» гэж заналхийлсэн тохиолдол 14 гарсан нь нэгийг бодогдуулмаар.

Заналхийлээд өнгөрвөл нэг хэрэг. Хамгийн аюултай нь заналхийлэл хэрэгжих явдал юм. Нийт заналхийллийн 26.5% нь хэрэгжиж байгаа нь

өндөр үзүүлэлт билээ. Мэдээж, өдөр тутмын мэдээнд гүйж байгаа сэтгүүлчийг тэр бүр заналхийлээд, эрх чөлөөнд нь халдаад байх нь юу л бол. Ямар асуудлыг хөндсөний дараа сэтгүүлч заналхийлэлд өртсөн бэ гэвэл дараах дүр зураг бууж байна (давхардсан тоогоор). Том албан тушаалтны тухай

«Заналхийлэл, сүрдүүлэг хэнээс гараад байна вэ гэдэг мөн сонирхол татсан асуудал.
Заналхийлэгч нь (давхардсан тоогоор) 46 тохиолдолд нийтлэл, нэвтрүүлэгт дурдагдсан хүн, түүний хамсаатан, гарын доор байдаг хүн, тус бүр 22 тохиолдолд нэрээ хэлэхээс татгалзсан хүн, таньдаг хүн, 8 тохиолдолд бусад хүн байна.

»

нийтлэл, нэвтрүүлгийн дараа (31 тохиолдол), гэмт хэргийн тухай нийтлэл, нэвтрүүлгийн дараа (21), сонгуулийн тухай тухай нийтлэл, нэвтрүүлгийн дараа (18), авлигын тухай тухай нийтлэл, нэвтрүүлгийн дараа (14) сэтгүүлч гол төлөв заналхийлэлд өртөж байна. «Бусад» гэсэн хариултыг (хүний хувийн амьдрал, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийтлэл, нэвтрүүлэг) 14 респондент өгчээ. Өндөр албан тушаал хашдаг хүн сэтгүүлчийн гол дайсны нэг гэж үзэж болох юм.

Аливаа заналхийлэл, сүрдүүлэг, бие махбодид халдах явдал зүгээр өнгөрдөггүй, заавал ул мөр үлдээдэг. Сэтгүүлчийн зориг мохож байна уу, аль эсвэл харин ч хор шар нь буцалдаг уу? Эрх нь зөрчигдсөн 68 эмэгтэй сэтгүүлчийн 34 нь «Би хурц сэдэв хөнддөг хэвээрээ» хэмээн омог бардам хариулсан нь баярлууштай үзүүлэлт мөн. Харамсалтай нь бүгд ийм байж чадахгүй нь ойлгомжтой. 26 нь хурц сэдэв хөндөхөөс эмээдэг, өөрийгөө цензурддэг болсон, 6 нь хурц сэдэв хөндөхөө огт больсон байна. «Бусад» гэсэн хариултыг 2 респондент өгчээ. Заналхийлэгч этгээд, сэтгүүлчийн бие махбодид шууд халдахгүй ч элдвийн дарамт, сүрдүүлгээрээ тэдний амыг барьж чаддаг нь эмзэглэмээр үзэгдэл мөн.

Сэтгүүлчийн эрхэд халдах үзэгдэл хэр түгээмэл болох талаар сэтгүүлчид маань өөрсдөө юу гэж бодож явдаг нь сонирхолтой. Ингэхэд ердөө З-хан хувь нь «Өөр сэтгүүлчид ийм зүйл тохиолдож байсан гэж сонсоогүй» гэж хариулсан бол 31% нь «Түгээмэл биш», харин 46% нь «Энгийн үзэгдэл болсон» гэж үздэг ажээ. Респондентуудын 20% нь «Хариулж мэдэхгүй байна» гээн хариултыг сонгожээ.

Эцэст нь бид сэтгүүлчдийг заналхийлэл, сүрдүүлэг, аливаа хэлбэрийн дарамтнаас хэн хамгаалах ёстой талаар сэтгүүлчид маань өөрсдөө юу бодож явдгийг сонирхсон юм (давхардсан тоогоор). Биднийг мэргэжлийн байгууллага хамгаалах ёстой гэж судалгаанд хамрагдагсдын 59 нь хариулсан бол 42 нь төр, 38 нь тухайн сэтгүүлчийн ажилладаг ХМХ, 27 нь

сэтгүүлчид өөрсдөө гэжээ. «Бусад» гэсэн хариултыг 2 сэтгүүлч дугуйлжээ.

Мөн судалгаанд хамрагсад хуулинд тусгах, хууль-эрх зүйн орчинг бүрдүүлэх, бие хамгаалах хэрэгслээр хангах (нулимс асгаруулагч г. м.), ийм аргыг сэтгүүлчдэд заах, эх сурвалжаа нууцлах эрхийг хуульчлах, төрөөс сэтгүүлчдийн өдөр тутмын ажилд хутгалдаахаа зогсоох зэрэг санал, шаардлагыг тавьсан юм.

«Төр, нийгмийн зүтгэлтэн болон бизнесменүүдтэй холбоотой гэмт хэрэг, авилгын чанартай нэвтрүүлэг бэлдэхэд дээрээс заавал хорьдог. Энэ нь нэг талаас сэтгүүлчдийн зоригийг мохоход хүргэдэг», «Аливаа байгууллагын албан тушаалтан, дарга нар эмэгтэй сэтгүүлчдийн (зарим нэг) ажил үүргийг өөрсдийн дураар зохицуулж бүр цаашлаад албан тушаалын хүчирхийлэл энгийн үзэгдэл мэт болсон юм шиг ээ», «Сонины маань эзэн эргэж хараад наймаалцихдаггүй, сэтгүүлчээ эцсийн мөч хүртэл хамгаалдагсан бол бидний өмнөөс дур мэдэн, яаран запруулга нийтэлчихдэггүй, шүүх дээр очсон ч нотлох баримт олохын төлөө хөрөнгө хүч хаяж сэтгүүлчтэйгээ хамтран ажилладаг бол бидний ажил хичнээн сайхан өрнөх бол...», «Сэтгүүлчдийн мэргэжлийн эрх ашиг, нэр төрийг хамгаалдаг бие даасан байгууллагатай болмоор байна» зэрэг саналыг ч мөн дэвшүүлсэн байна.

Судалгааны дүн дээрээ тулгуурлан бид дараах дүгнэлтийг хийж байна.

1-рт, сэтгүүлчдийн эрх хөндөгдөх нь энгийн үзэгдэл болжээ.

2-рт, сэтгүүлчид албан тушаалт-нуудын төдийгүй, эрхлэгчдийнхээ зүгээс заналхийлэлд өртдөг, элдвээр дарамтлуулдаг байна.

З-рт, эрх нь зөрчигдсэн сэтгүүлчид хандах газаргүйгээс мухардалд ордог, цаашлаад хурц сэдвийг хөндөх зориг нь мохдог байна.

Эмэгтэй гэлтгүй, ер нь нийт сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан тусгай заалтуудыг Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний хуульд яаралтай оруулах шаардлагатай, энэ тал дээр мэргэжлийн байгууллагууд тодорхой алхам хийх цаг болсныг энэхүү судалгааны дүн харуулж байна.

качестве которых выступили журналистки. Исследование наглядно показало, что в нашем обществе расправа с журналистами (вплоть до физической) стала распространённым явлением, не говоря уже о давлении со стороны своих же хозяев, редакторов и телефонных звонках «доброжелателей» и лиц, интересы которых были затронуты выступлением журналистки.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Аверьянов Л. Я. 1993. Социология: что она знает и может. М.
2. Буданцев Ю. П. 1995. Социология массовой коммуникации. М.
3. Дюргейм Э. 1995. Социология. М.
4. 1994. Журналист: социологические и социопсихологические исследования. М.
5. 1990. Как провести социологическое исследование. М.
6. Конецкая В. П. 1997. Социология коммуникации. М.
7. Кравченко А. И. 1998. Социология. М.
8. Смелзер Н. 1994. Социология. М.
9. 1981. Социология журналистики. Под ред. проф. Е. П. Прохорова. М.
10. 1998. Социология журналистики. М.
11. 1996. Социология: наука об обществе. Харьков.

Резюме

Эта статья представляет собой отчёт социологического исследования, проведённого методом анкетирования респондентов, в